



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/393

Баруун-Урт сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баруун-Урт сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй М.Мөнхзаяа захиралтай "Сүхбаатар моми хүнс" ХХК-ийн "Моми" хүнсний дэлгүүр, Асгат сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах С.Энхтуяа захиралтай "Маралын ягаан" ХХК-ийн "Хоёр Эрдэнэ" хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Т.Оюунбилэг захиралтай "Ану-Сонн" ХХК-ийн "Оч хур" хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Э.Дэлгэрмаа захиралтай "Хоролдэлгэр" ХХК-ийн "Гүнбулаг" зоогийн газар, Асгат сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Аззаяа захиралтай "Содон дөрвөн эрдэнэ" ХХК-ийн "Содон" хүнсний дэлгүүр, Мөнххаан сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Т.Наранчимэг захиралтай "Буян арвижих их уул" ХХК-ийн "Их уул" хүнсний дэлгүүр, Онгон сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Г.Амарзаяа захиралтай "Түвшин арвин" ХХК-ийн "Түвшин" хүнсний дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай сунгаж, Халзан сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй "Ар булаг оргих" ХХК-ийн "Ар булаг" хүнсний дэлгүүр, Сүхбаатар сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй "Баян мөнх хундар" ХХК-ийн "Баянбүрд-2" хүнсний дэлгүүр, Баруун-Урт сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй "Сүлд их уул" ХХК-ийн "Мөнх маркет" хүнсний дэлгүүрт өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл сунгагдсан болон шинээр олгогдсон аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Энхцэцэг), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа

2222010786

Б.Гантулга), Мэргэжлийн хяналтын газар (С.Нямжав), Стандарт хэмжил зүйн хэлтэс (Д.Эрдэнэбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг дээрх аж ахуй нэгжүүдийн захирлуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ